

## **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ**

Огноо: 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: **Хоролжингийн үйлдвэрийн барилгын зураг, төсөв тоног төхөөрөмжийн суурийн зураг боловсруулах**  
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202312475**

“Монголросцветмет” ТӨҮГ нь **“Хоролжингийн үйлдвэрийн барилгын зураг, төсөв тоног төхөөрөмжийн суурийн зураг боловсруулах”** зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших Бор-Өндөрийн УБҮ-ийн дэргэд баригдах Хорголжингийн үйлдвэрийн барилгын зураг, төсөв тоног төхөөрөмжийн суурийн зураг боловсруулах.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,
- Тусгай зөвшөөрөл
- Сүүлийн 3 жилд уул уурхай, үйлдвэрийн зураг төсөл боловсруулж байсан тухай туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээ дүгнэсэн актын хамт/,
- Татварын өргүй тухай тодорхойлолт зэргийг ирүүлнэ.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2023 оны 08 дугаар сарын 17–ны өдрийн 10 цагаас** өмнө авч болох бөгөөд **2023 оны 08 дугаар сарын 22–ны өдрийн 10 цагаас** өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**